



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 4/121

Булган сум

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин
үүсэж байгуулагдсаны 104 жилийн ойг
тэмдэглэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.10, Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний 1.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 104, Халх голын дайны ялалтын 86 жилийн ойг тусгай төлөвлөгөө гаргаж, шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 104, Халх голын байлдааны ялалтын 86 жилийг тохиолдуулан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд аймгийн Засаг даргын нэрэмжит "Марш, тусгай бэлтгэл"-ийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр сахилга, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Цэргийн штаб (Хурандаа Ч.Энхбаяр), Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Н.Хишигдорж)-д хариуцуулсугай.


3. Тэмцээнүүдийн шагналын зардал 6,540,000 (зургаан сая таван зуун дөчин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс хавсралтын дагуу зарцуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 15-ны/ний өдрийн А/121 дүгээр
захирамжийн хавсралт



ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

д/д	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ	Бүгд
1	2	3	4
1	“Марш, тусгай бэлтгэл”-ийн аварга шалгаруулах тэмцээний зардал	3.740.000	1-р байр 1.000.000 2-р байр 800.000 3-р байр 600.000 Өргөмжлөл $5 \times 100.000 = 500.000$ Медаль $33 \times 20.000 = 660.000$ Буудлагын тэмцээний медаль $9 \times 20.000 = 180.000$
2	Зэвсэгт хүчний 104, Халх голын байлдааны 86 жилийн ойн нэрэмжит насанд хүрэгчид, өсвөр үеийн аварга шалгаруулах хийн буудлагын тэмцээний зардал	1.300.000	1-р Байр $4 \times 50.000 = 200.000$ 2-р Байр $4 \times 40.000 = 160.000$ 3-р Байр $4 \times 30.000 = 120.000$ Медаль $12 \times 20.000 = 240.000$ Шүүгч 2хүн $40.000 = 80.000$ Сум 2 хайрцаг 500.000 Нийт – 1.300.000
3	Монгол улсад хурандаа цол үүссэний 89 жилийн ойг тохиолдуулан Булган аймагт ажиллаж амьдарч байгаад бэлтгэл, чөлөөнд гарсан “Хурандаа” нарт хүндэтгэл үзүүлэх	1.500.000	Гарын бэлэг хүн $15 \times 50.000 = 750.000$ Хүндэтгэлийн зоог, $15 \times 50.000 \text{ төг} = 750.000$
БҮГД			6.540.000